



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН ДЭРГЭДЭХ ДОПИНГИЙН

ДАВЖ ЗААЛДАХ КОМИСС

ХЭВЛЭЛИЙН МЭДЭЭ

2023.12.04

*Монгол Улсын харцага Ц.Мөнхбаяр, Аймгийн арслан Б.Өсөхбаяр
нараас Монголын Үндэсний Бөхийн Холбоо НҮТББ-д холбогдуулан
гаргасан өргөдлийг хүлээн авч шийдвэрлэлээ.*

Монголын Үндэсний Бөхийн Холбоо НҮТББ-ын Тэргүүлэгчдийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн №69 дугаар тогтоолын Улсын харцага Ц.Мөнхбаяр, Аймгийн арслан Б.Өсөхбаяр нарт холбогдох хэсэг нь Допингийн эсрэг үндэсний дүрэм, Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандартыг зөрчсөн болохыг тогтоолгож, уг шийдвэрийг хүчингүй болгох, барилдах эрхийг сэргээхийг Монголын Үндэсний бөхийн холбоо НҮТББ-д даалгах өргөдлийг 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдөр гаргасан болно.

Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын дэргэдэх допингийн Давж заалдах комисс тус маргааныг Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 13.2 дахь хэсэг, Допингийн эсрэг үндэсний дүрмийн 1.3-д тус тус заасны дагуу өөрийн харьяалан шийдвэрлэх маргаан гэж үзэн хүлээн авч, хэрэг хянан шийдвэрлэх (үр дүнгийн удирдлага) ажиллагааг хэрэгжүүлэн явууллаа.

Давж заалдах комисс 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Монголын үндэсний бөхийн холбоо НҮТББ-ын Тэргүүлэгчдийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн №69 дугаартай тогтоолын Улсын харцага Ц.Мөнхбаяр, Аймгийн арслан Б.Өсөхбаяр нарт холбогдох хэсэг нь Допингийн эсрэг үндэсний дүрэм болон Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандартыг зөрчсөн болохыг тогтоож хүчингүй болгож, барилдах эрхийг сэргээхийг даалгах хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ.

Допингийн эсрэг үндэсний дүрмийн 13 дугаар зүйлийн 13.23-т зааснаар Монголын Үндэсний Бөхийн Холбоо НҮТББ шийдвэрийг хүлээн авснаас хойш 21 /хорин нэг/ хоногийн дотор Олон улсын спортын арбитрын шүүх (The Court of Arbitration of Sport (CAS)-д гомдол гаргаагүй тохиолдолд Давж заалдах комиссоос гаргасан шийдвэр хүчин төгөлдөр болно.